



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Хүрмэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ӨМА-2022/89-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.umnugovi@audit.gov.mn](http://www.umnugovi@audit.gov.mn)  
Даланзадгад сум  
2022 он

ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр  
Утас: 70533539 Цахим хаяг: [tserenbayars@audit.gov.mn](mailto:tserenbayars@audit.gov.mn)  
Аудитын менежер: Т.Хонгорзул  
Утас: 70533552 Цахим хаяг: [khongorzult@audit.gov.mn](mailto:khongorzult@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Ж.Болормаа  
Утас: 70533539 Цахим хаяг: [Bolormaaja@audit.gov.mn](mailto:bolormaaja@audit.gov.mn)  
Аудитыг гүйцэтгэсэн: “Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК  
Утас: 77270808 Цахим хаяг: [nitsbalance@gmail.com](mailto:nitsbalance@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

46083, Өмнөговь аймаг, Даланзадгад сум, 3 дугаар баг,  
Нутгийн удирдлагын ордон 304 тоот  
Утас: (976) 7053 3539, Вэб сайт: www.audit.mn  
И-мэйл: umnugovi@audit.gov.mn

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХҮРМЭН  
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Ц.МАЙНБАЯР ТАНАА

2022.02.21 № 67

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Өмнөговь аймгийн Хүрмэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өмнөговь аймгийн Хүрмэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 Ц.МАЙНБАЯР

D:\2021 Он\Бичиг Хэрэглэсэн Бичиг\2022-02-21 №67 г



Нэг.

### Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

|                                                | Үзүүлэлт                                          | 2020.12.31     | 2021.12.31     |
|------------------------------------------------|---------------------------------------------------|----------------|----------------|
| /сая төгрөгөөр/                                |                                                   |                |                |
| <b>Санхүүгийн байдлын тайлан</b>               |                                                   |                |                |
|                                                | Эргэлтийн хөрөнгийн дүн                           | 84.7           | 84.8           |
|                                                | Эргэлтийн бус хөрөнгийн дүн                       | 1,430.2        | 1,738.8        |
|                                                | <b>Нийт хөрөнгийн дүн</b>                         | <b>1,514.9</b> | <b>1,823.6</b> |
|                                                | Нийт өр төлбөрийн дүн                             | 0.0            | 0.0            |
|                                                | Цэвэр хөрөнгө/өмчийн дүн                          | 1,514.9        | 1,823.6        |
|                                                | <b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>        | <b>1,514.9</b> | <b>1,823.6</b> |
| <b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>            |                                                   |                |                |
|                                                | Үйл ажиллагааны орлогын дүн                       | 681.6          | 960.9          |
|                                                | Үйл ажиллагааны зардлын дүн                       | 649.9          | 652.2          |
|                                                | <b>Үйл ажиллагааны үр дүн</b>                     | <b>31.7</b>    | <b>308.7</b>   |
|                                                | Үйл ажиллагааны бус үр дүн                        | -127.7         |                |
|                                                | <b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>                | <b>96.0</b>    | <b>308.7</b>   |
| <b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b> |                                                   |                |                |
|                                                | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                        | 581.3          | 581.3          |
|                                                | Тайлант оны үр дүн                                | 933.6          | 1,242.3        |
|                                                | <b>Эцсийн үлдэгдэл</b>                            | <b>1,514.9</b> | <b>1,823.6</b> |
| <b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>                |                                                   |                |                |
|                                                | Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн                | 544.2          | 565.5          |
|                                                | Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн               | 542.4          | 565.3          |
|                                                | <b>Үйл ажиллагааны ЦМГ</b>                        | <b>1.8</b>     | <b>0.2</b>     |
|                                                | <b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>                     |                |                |
|                                                | <b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>                 |                |                |
|                                                | <b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>                  |                |                |
|                                                | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл  | 0.0            | 0.0            |
|                                                | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | <b>0.0</b>     | <b>0.0</b>     |
| <b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>             |                                                   |                |                |
|                                                | <b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>          |                | <b>471.9</b>   |
|                                                | Урсгал зардал                                     |                | 471.9          |
|                                                | Хөрөнгийн зардал                                  |                |                |
|                                                | <b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>             |                | <b>471.9</b>   |
|                                                | Улсын төсвөөс санхүүжих                           |                | 391.2          |
|                                                | Орон нутгийн төсвөөс                              |                | 80.7           |

### Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын зорилгоо сургуулийн зорилгын хэрэгжилтийг хангах, сургалтын тасралтгүй үйл ажиллагааг дэмжих гэж тодорхойлсон ба дараахь зорилтуудыг дэвшүүлжээ. Үүнд:



- ✚ Уламжлалт ажлуудыг цар тахлын нөхцөл байдалд тохируулан зохион байгуулах;
- ✚ Цаг үеийн нөхцөл байдалд тохируулан зохион байгуулах;
- ✚ Сургууль, эцэг эх, Олон нийтийн байгууллагуудын хамтын ажиллагааны тасралтгүй байдлыг дэмжих;
- ✚ Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ✚ Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”;
- ✚ МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- ✚ МУЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- ✚ Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”;
- ✚ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д: “Нягтлан бодогч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөж ажиллана”; /2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/
- ✚ МУЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор баталсан “Ковид 19” цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай”;
- ✚ МУЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 267 дугаар тушаалаар баталсан “Цахилгаан, дулааны уурын хангамж, хэрэглээг зохицуулах тухай”.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” гэж заасны дагуу 2020-2021 оны хичээлийн жилд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам боловсруулаагүй, хяналт шалгалтын баг зохион байгуулаагүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.



Өмнөговь аймгийн Хүрмэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### **Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Дэлхийн нийтээр ковид-19 өвчлөлтэй холбоотойгоор Боловсрол Шинжлэх Ухааны Яамны /БШУЯ/-ны сайдын тушаалын дагуу сургалтын үйл ажиллагаа 3, 9, 10, 11, 12 саруудад буюу 5 сар танхимаар явуулсан нь батлагдсан төсөвт зардал буурахад нөлөөлсөн байна.

### **Дөрөв. Аудитын гол асуудал**

Төсөв санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батлагдсан төсвийг тухайн байгууллагад албан бичиг, шийдвэр хавсарган ирүүлдэггүй, төсвийн төсөлтэй холбоотой тайлбар тодруулга авахгүйгээр төсвийг үндэслэлгүй хассан байна. Төсвийн тодотголыг хууль тогтоомжид нийцүүлээгүйд, төсвийг бүлэг хооронд шилжүүлэн зориулалт бусаар зарцуулахад тавих хяналт сул байгааг цаашид анхаарах шаардлагатай.

Өмнөговь аймгийн Хүрмэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 чиглэлээр 17 арга хэмжээг төлөвлөснөөс, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 98.0 хувийн хэрэгжилттэй тайлагнасан байна.

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй болно.

### **Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

### **Долоо. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 6,398.4 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс, 4,300.0 мянган төгрөгийн 1 алдаа зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 2,098.4 мянган төгрөгийн 3 алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн ба залруулагдаагүй 6,398.4 мянган төгрөгийн алдаа зөрчил, тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшинээс 4,601.6 мянган төгрөгөөр бага тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

### **Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулга завсрын аудитын явцад бүрэн хийгдсэн.



## **Албан шаардлага**

Тайлант хугацаанд боловсрол чанар-5 төслийн хүрээнд сурагчдын хоцрогдол арилгах чиглэлээр 4,300.0 мянган төгрөгийн ажил хийгдээгүйгээс авлага шинээр үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д: "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

## **Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **1. Данс бүртгэл, ангилалтай холбоотой асуудал**

#### **1.1. Илрүүлэлт:**

Мөнгөн гүйлгээний тайлангийн дүнгээс, санхүүгийн үр дүнгийн тайланд хангамж, бараа материал-680.8 мянган төгрөгөөр, нормативт зардал-781.6 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засвар-251.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал-385.0 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй ба дээрхи зардлыг бусад хангамжийн материал зардалд ангилж бүртгэсэн байна.

#### **1.2. Эрсдэл:**

УСНББОУС 27-д: “санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой”, НББОУС 8-ын 10.Б.1-д: “аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, санхүүгийн гүйцэтгэл ба мөнгөн гүйлгээг үнэн зөв илэрхийлэх”, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” гэж заасантай тус тус нийцэхгүй, эрх ба үүрэг, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **1.3. Өгсөн зөвлөмж:**

УСНББОУС 27, НББОУС 8-ын 10.Б.1 дэх заалтууд, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын дагуу ажил гүйлгээг зөв дансанд ангилан бүртгэж, толилуулж байх

### **2. Дотоод хяналттай холбоотой асуудал**

#### **2.1. Илрүүлэлт:**

МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” гэж заасны дагуу 2020-2021 оны хичээлийн жилд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам боловсруулаагүй, дотооддоо хяналт шалгалтын баг зохион байгуулаагүй байна.

#### **2.2. Эрсдэл:**

МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

#### **2.3. Өгсөн зөвлөмж:**

МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журам боловсруулж, дотооддоо хяналт шалгалтын баг ажиллуулах



## 7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо |                             |                    |                 | Санал дүгнэлтийн хэлбэр |                |       |                            |
|---|-----------------------------|--------------------------|-----------------------------|--------------------|-----------------|-------------------------|----------------|-------|----------------------------|
|   |                             | Аудитад хамрагдах        | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр |                    |                 | Зөрчилгүй               | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
|   |                             |                          | Санал дүгнэлт гаргасан      | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй |                         |                |       |                            |
| A | 1                           | 2                        | 3                           | 4                  | 5               | 7                       | 8              | 9     | 10                         |
| 1 | ТШЗ                         | 1                        | 1                           |                    |                 | 1                       |                |       |                            |
| 2 | Төсөл, хөтөлбөр             |                          |                             |                    |                 |                         |                |       |                            |
| 3 | ЗГТС                        |                          |                             |                    |                 |                         |                |       |                            |
| 4 | ТТЗ                         |                          |                             |                    |                 |                         |                |       |                            |
| 5 | ТЕЗ                         |                          |                             |                    |                 |                         |                |       |                            |
|   | <b>НИЙТ</b>                 | <b>1</b>                 | <b>1</b>                    |                    |                 | <b>1</b>                |                |       |                            |

## 7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

| № | Төсвийн захирагчийн ангилал | Нийт алдаа, зөрчлийн |            | Үүнээс    |     |               |            |                 |            |          |            |
|---|-----------------------------|----------------------|------------|-----------|-----|---------------|------------|-----------------|------------|----------|------------|
|   |                             |                      |            | Залруулга |     | Төлбөрийн акт |            | Албан шаардлага |            | Зөвлөмж  |            |
|   |                             | Тоо                  | Дүн        | Тоо       | Дүн | Тоо           | Дүн        | Тоо             | Дүн        | Тоо      | Дүн        |
| A | 1                           | 2                    | 3          | 4         | 5   | 6             | 7          | 8               | 9          | 10       | 11         |
| 1 | ТШЗ                         | 4                    | 6.4        |           |     | 0.0           | 0.0        | 1               | 4.3        | 3        | 2.1        |
| 2 | Төсөл, хөтөлбөр             |                      |            |           |     |               |            |                 |            |          |            |
| 3 | ЗГТС                        |                      |            |           |     |               |            |                 |            |          |            |
| 4 | ТТЗ                         |                      |            |           |     |               |            |                 |            |          |            |
| 5 | ТЕЗ                         |                      |            |           |     |               |            |                 |            |          |            |
|   | <b>НИЙТ</b>                 | <b>4</b>             | <b>6.4</b> |           |     | <b>0.0</b>    | <b>0.0</b> | <b>1</b>        | <b>4.3</b> | <b>3</b> | <b>2.1</b> |